



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/52

Чойр

Ажлын хэсэг томилох тухай

Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, Засгийн газрын 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.1, 2.1.2.6 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймгийн Засаг даргын Тамгын газрын брэндбүүк”-ийг хүлээн авах, ашиглалтанд оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

М.Анхбаяр

(Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Н.Батцэцэг

(Хяналт-шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн дарга)

Б.Нэргүйцэцэг

(Хууль, эрх зүйн хэлтсийн
дарга)

Т.Баясгалан

(Нийгмийн бодлогын хэлтсийн
даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

Г.Хонгор

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

У.Занабазар

(Санхүү, төрийн сангийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Гарамсүрэн


(Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн
мэргэжилтэн)

Гүйцэтгэгч:

Э.Өлзий

(Луна дизайн ХХК-ийн гүйцэтгэх захирал)

2.Аймгийн Засаг даргын Тамгын газрын брэндбүүкийг холбогдох хууль, журмын дагуу 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн дотор хүлээн авч, ашиглалтанд оруулахыг ажлын хэсгийн дарга (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* Д.СОДНОМ